



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар A/53

Арвайхээр

**Олон нийтийн эргүүлд төрийн албан  
хаагчдыг ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 328 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэдийг Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл түгээх, иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих, хүн амын эрүүл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгах зорилгоор “Олон нийтийн эргүүл”-ээр төрийн байгууллагуудын албан хаагчдыг татан ажиллуулсугай.

2.Олон нийтийн эргүүлд ажиллах төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгжийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Олон нийтийн эргүүлд ажиллах алба хаагчдад шаардагдах автомашин, шатахуун, хантааз, маск, бээлий, гар ариутгагч зэргийг тухайн байгууллагаас хариуцан, хуваарьт өдөр 4-өөс доошгүй албан хаагчдыг олон нийтийн эргүүлээр ажиллуулахыг байгууллагын удирдлагуудад даалгасугай.

4.Олон нийтийн эргүүлд ажиллах албан хаагчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат)-д үүрэг болгосугай.

5.Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлын үед олон нийтийн эргүүлээр ажиллах байгууллагуудын ажлын зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100118

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 47/33 дүгээр захирамжийн хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
 ҮҮРЭГ БҮХИЙ ОЛОН НИЙТИЙН ЭРГҮҮЛД АЖИЛЛАХ ТӨРИЙН  
 БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ  
 АЖ АХУЙ НЭГЖИЙН ХУВААРЬ

д/д	Байгууллага, аж ахуй нэгжийн нэр	Ажиллах хугацаа цагийн хуваарь /11-15 цаг, 15-19 цагийн хооронд/
1.	Байгаль орчин аялал жуулчлалын газар	2021-02-02
2.	Биеийн тамир, спортын газар	2021-02-03
3.	Боловсрол, соёл, урлагийн газар	2021-02-04
4.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	2021-02-05
5.	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	2021-02-06
6.	Орон нутгийн өмчийн газар	2021-02-07
7.	Санхүү хяналт, аудитын алба	2021-02-08
8.	Стандарт хэмжил зүйн хэлтэс	2021-02-09
9.	Статистикийн хэлтэс	2021-02-10
10.	Татварын хэлтэс	2021-02-11
11.	Улсын бүртгэлийн хэлтэс	2021-02-12
12.	Ус цаг уур орчны шинжилгээний алба	2021-02-13
13.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	2021-02-14
14.	Хүнс, хөдөө аж ахуйн газар	2021-02-15
15.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	2021-02-16
16.	Шүүхийн шинжилгээний алба	2021-02-17
17.	Нийгмийн даатгалын хэлтэс	2021-02-18
18.	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	2021-02-19
19.	Мал эмнэлгийн газар	2021-02-20
20.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба	2021-02-21
21.	Аймгийн Засаг даргын Тамгын газар	2021-02-22
22.	Арвайхээр сумын иргэдийн Төлөөгчдийн Хурал, Арвайхээр сумын хотын захирагчийн алба	2021-02-23
23.	Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар	2021-02-24
24.	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	2021-02-25
25.	Онги-Таац голын сав газрын захиргаа	2021-02-26
26.	Насан туршийн боловсрол төв, Гэр бүл хүний хөгжлийн төв	2021-02-27
27.	Аймгийн Хөгжимт драмын театр	2021-02-28
28.	Аймгийн Музей, Төв номын сан	2021-03-01
29.	Өвөрхангай аймаг дахь Авто тээврийн төв	2021-03-02
30.	ӨВ-АЗЗА ТӨХК	2021-03-03
31.	ЭБЦТС-ТӨХК	2021-03-04
32.	Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Шуудан холбооны газар, Цахилгаан холбоо ХК-ны Өвөрхангай аймаг дахь холбооны газар	2021-03-05